

БАТЛАВ  
УЯАНГА СУМЫН БУСЫН СУРГУУЛЬ  
ЗАХИРАЛ Т.ТУУЛ

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

### 1. Ажил гүйцэтгэх хүний нөөц:

Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага
Ерөнхий инженер	1	Барилгын инженер	3 ба түүнээс дээш жил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны үнэмлэхтэй байна	2 ба түүнээс дээш жил
Мэргэжилтэй ажилчид	2-оос дээш	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	1 ба түүнээс дээш жил

- Хүснэгтэд шаардсан ажилчдын ажилласан жилийн туршлагыг нотлох Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг "E Mongolia"–оос татаж, сканердаж ирүүлнэ.
- Мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн үнэмлэх, иргэний үнэмлэхийг зөвхөн эх хувиас
- ХАБЭА-н ажилтан нь зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай, гэрчилгээг эх хувиас сканердаж ирүүлэх
- Хэрэв ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ ирүүлнэ. Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн тендерт зориулсан байх бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцлийг тодорхой тусгасан байна.
- Тухайн ажилд ашиглагдах бүх бараа, материал нь сүүлийн үеийн технологийн шаардлага хангасан, аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
- Ажил гүйцэтгэх машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хүчин чадлыг зургаар тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх

### 2. Ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлага:

- Ажил гүйцэтгэх нарийвчилсан ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.
- Ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
- Гүйцэтгэгч нь ашиглагч, захиалагч байгууллагатай уялдаа холбоотой ажиллана.
- Ажлыг гүйцэтгэх үед нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, инженерийн шугам, зогсоол, явган зам, холбоо, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө.

- Гүйцэтгэгч байгууллага нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны дүрэм журамыг бүрэн хангах, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.
- Ажил үйлчилгээг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэн захиалгач байгууллагад 60 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

-oOo-